



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/792

Ховд

Боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа болон  
бусад үйл ажиллагааг түр зогсоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в" заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотод Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвүүд, үзвэр үйлчилгээний байгууллага, олон нийтийг хамарсан хурал цуглаан, сургалт, соёл урлаг, спортын тэмцээн уралдаан, тоглоомын газруудын үйл ажиллагааг зогсоох тухай аймгийн Засаг даргын 2020 оны А/694 дүгээр захирамжийн хэрэгжилтийг сунгасан аймгийн Засаг даргын А/705 дугаартай захирамжийн хэрэгжилтийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06.00 цаг хүртэл сунгасугай.

2. Дээрх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар /М.Пүрэвхүү/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ч.Уранчимэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ